



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 106

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Засгийн газрын авто бааз" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 630,100,000.00 (зургаан зуун гучин сая нэг зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 84,329,166.61 (наян дөрвөн сая гурван зуун хорин есөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг жаран нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Үндэсний аудитын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Үндэсний аудитын газрын Тамгын дарга, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, "Засгийн газрын авто бааз" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
132000336
5-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн
 106 дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуриятлагдсан элэгдэл(төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Тоёота Ландкрузер-300, Улсын дугаар /01-21 УБЗ/, Арлын дугаар /JTMABVBJ804096498/	10/11/23	ш	1	296,100,000.00	37,012,500.00	259,087,500.00
2	Ниссан Патрол-У62, Улсын дугаар /01-02 УБЗ/, Арлын дугаар /JNITANY62Z0155804/	09/01/23	ш	1	334,000,000.00	47,316,666.61	286,683,333.39
Нийт дүн				2	630,100,000.00	84,329,166.61	545,770,833.39
					(зургаан зуун гучин сая нэг зуун мянга)	(наян дөрвөн сая гурван зуун хорин есөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг жаран нэгэн мөнгө)	(таван зуун дөчин таван сая долоон зуун далан мянга найман зуун гучин гурван төгрөг гучин есөн мөнгө)